

# Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат Бус Аудиторын Тайлан

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО  
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

“АРД КРЕДИТ ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

## Дүгнэлт

Бид “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар журам, аргачлалын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

## Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Ард Кредит ББСБ” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

## Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

## Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

## Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



Б.ОСОРГАРЬ  
УДИРДАХ ПАРТНЕР

Монгол улс, Улаанбаатар хот  
2025 оны 3 дугаар сарын 31

# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,086,018	7,223,162
Зээл	68,112,669	49,974,680
Хөрөнгө оруулалт	7,819,759	4,915,395
Бусад санхүүгийн хөрөнгө	6,627,523	1,969,937
<b>Санхүүгийн хөрөнгийн дүн</b>	<b>89,645,969</b>	<b>64,083,174</b>
<b>Үндсэн хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	512,313	685,128
Биет бус хөрөнгө	19,122,441	2,737,697
Ашиглах эрхтэй хөрөнгө	604,397	182,719
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	441,859	334,211
Бусад санхүүгийн бус хөрөнгө	5,171,250	3,982,617
<b>Санхүүгийн бус хөрөнгийн дүн</b>	<b>25,852,260</b>	<b>7,922,372</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>115,498,229</b>	<b>72,005,546</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	33,352,630	25,570,990
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	19,641,858	16,044,694
Бусад эх үүсвэр	13,434,392	-
Бусад санхүүгийн өр төлбөр	10,051,060	7,968,454
<b>Санхүүгийн өр төлбөрийн дүн</b>	<b>76,479,940</b>	<b>49,584,138</b>
<b>Татвар НДШ-ийн өр төлбөр</b>		
Татвар НДШ-ийн өр төлбөр	523,970	460,861
Хойшлогдсон татварын өр төлбөр	851,557	106,847
Бусад санхүүгийн бус өр төлбөр	667,759	948,791
<b>Санхүүгийн бус өр төлбөрийн дүн</b>	<b>2,043,286</b>	<b>1,516,499</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>78,523,226</b>	<b>51,100,637</b>
<b>Эздийн өмч</b>		
Хувьцаат капитал	3,640,000	2,800,000
Халаасны хувьцаа	(32,226)	-
Нэмж төлөгдсөн капитал	12,440,333	5,352,792
Бусад өмч	3,497,276	(3,084,389)
Хоёрдогч өглөг	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг	12,429,620	10,836,506
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>36,975,003</b>	<b>20,904,909</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>115,498,229</b>	<b>72,005,546</b>

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	18,609,009	13,019,411
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(8,773,235)	(6,887,980)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>9,835,774</b>	<b>6,131,431</b>
Эрсдэлийн сангийн зардал	(2,856,452)	(2,840,634)
<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого</b>	<b>6,979,322</b>	<b>3,290,797</b>
<b>Бусад орлого</b>		
Хүүгийн бус орлого	6,276,635	4,730,883
Бусад орлого, олз	577,219	2,639,593
<b>Бусад зардал</b>		
Хүүгийн бус зардал	(9,125,485)	(7,672,701)
Бусад зардал, гарз	(276,093)	(37,201)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>4,431,598</b>	<b>2,951,371</b>
Орлогын татварын зардал	(497,206)	(432,710)
<b>Татварын дараах ашиг</b>	<b>3,934,392</b>	<b>2,518,661</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>6,690,064</b>	<b>308,643</b>
Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл	6,690,064	308,643
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>10,624,456</b>	<b>2,827,304</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг /төгрөгөөр/</b>	<b>10.9</b>	<b>9</b>